

ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ
“ТАЛХ ЧИХЭР” ХУВЬЦААТ КОМПАНИ
18070 ш/х-37, Улаанбаатар хот, Сэнгинхайрхан дүүвэг, 2^д-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Утас: 7017-1410, Факс: 7017-3377
Цахим шуудан: info@talkh-chikher.mn Цахим хуудас: www.talkh-chikher.mn

МД. 03.27 № 1152
танай _____ -ны № _____ -т

МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуульд зааснаар компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа Эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаат компани нь Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулж байхаар зохицуулсан.

Гэвч Дэлхий дахинд Коронавируст халдвар дэгдэж цар тахлын хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан Монгол улсын Засгийн Газраас улсын хэмжээнд 2020 оны 04-р сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

Энэ хүрээнд Улсын Онцгой Комиссын даргын 2020 оны 02-р сарын 13-ны өдрийн 04 тоот тушаалаар “Олон нийтийг хамрасан уулзалт, сургалт, семинар, ёслол хүндэтгэл, урлаг спортын арга хэмжээг зогсоосон” тул “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниуд хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа хувьцаа эзэмшигчдийг биеэр оролцуулан нэг дор цуглуулан хуралдуулах боломжгүй болсон.

Иймд манай компани үүсээд буй нөхцөл байдалд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан зохион байгуулах болсныг албан ёсоор мэдэгдэж байна.




М.БАЗАР УУГАН

"ТАЛХ ЧИХЭР" ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Талх Чихэр" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит хурал" 2020 оны 04-р сарын 20-ны өдрийн 14:00цагт Компанийн өөрийн байрны хурлын зааланд болохоор зарласан.

Гэвч Дэлхий дахинд Коронавируст халдвар дэгдэж цар тахлын хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан Монгол улсын Засгийн Газраас улсын хэмжээнд 2020 оны 04-р сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлыг зарласан. Энэ үед "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниуд хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа хувьцаа эзэмшигчдийг биеэр оролцуулан нэг дор цуглуулан хуралдуулах боломжгүй болсон.

Иймд манай компани үүсээд буй нөхцөл байдалд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд, зайны технологийг ашиглан зохион байгуулах болсныг албан ёсоор мэдэгдэж байна.

Хуралд оролцож, саналаа өгөх Хувьцаа эзэмшигчид 2020 оны 04-р сарын 06-ны өдрийн 10:00 цагаас 04-р сарын 20-ны өдрийн 13:00 цаг хүртлэх хугацаанд Компанийн байранд биеэр ирж бүртгүүлнэ үү.

Хэрэв Хувьцаа эзэмшигчид Цахим хуралд оролцохыг хүсвэл **Талх Чихэр ХК Хувьцаа эзэмшигчид** албан ёсны facebook группт бүртгүүлнэ үү.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2020 оны 04-р сарын 03-ны өдрөөр тасалбар болгоно.


Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд гаргасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
2. Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах,
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсөв батлах,
4. Ногдол ашиг хувиарлах тухай,

Хурлын материалтай биеэр ирж болон www.talkh-chikher.mn цахим хуудсаас танилцах боломжтой.

Жич: Бүртгэлийг иргэний үнэмлэхийг үндэслэж хийнэ.

Харилцах утас: 9913-4516, 9855-5575



"ТАЛХ ЧИХЭР" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ